



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 12 сарын 06 өдөр

Дугаар А/241

Бат-Өлзий сум

「**Чоно агнах ажлыг зохион байгуулах тухай**」

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 1.11 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын нутаг дэвсгэрт чонын тоо толгой эрс олширч айл өрх, иргэдийн мал сүрэг рүү халдаж хохирол ихээр учруулж байгаа тул хээл тээх, төрөлтийн хугацаанаас бусад үед чоно агнах ажлыг зохион байгуулж ажиллахыг багийн Засаг дарга (Ж.Нямтогтох, Д.Бямбасүрэн, С.Төмөр, Г.Пүрэвтогтох, Г.Бямбагарав, Д.Дэмиддавга) нарт даалгасугай.

2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч (Б.Янжиндулам), Цагдаагийн тасгийн экологийн цагдаа (дэслэгч Н.Загарзүсэм)-д нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Н.ОРХОНТУУЛ

